Ё.ЖАНЧИВ
Ц.БЯМБАЦЭНД

НАНГИАД МОНГОЛ

"ХУА-И И-ЮЙ" ТОЛЬ

"華夷譯語"

11037

Арнутган шүүсэн: доктор, профессор Л.Болд

Улаанбаатар хот
2003 он

Yo.JANCHIV
Ts.BYAMBATSEND

THE CHINESE-MONGOLIAN GLOSSARY

"HUA-I I YU"

"華夷譯語"

Edited by: Doctor, professor L.Bold

Ulaanbaatar 2003

УДИРТГАЛ

Дундад үеийн монгол хэлний нангиад үсгийн дурсгалын тойм

Эдүгээ баттай судлагдаад байгаа монгол хэлний ан: бичгийн дурсгалууд XIII-XIV зууны үеэс уламжлан иржээ. Тодор: хэлбэл, 1224-1225 оны орчим бичигдсэн гэж үздэг уйгуржин мон үсгээр буй "Чингисийн чулууны бичиг"–ээс эхэлдэг гэж хэлж болно

Үүнээс өмнөх үед холбогдох хятан бичгийн дурсгал зэрэг з байх боловч одоо болтол хараахан бүрэн тайлан уншиж чадаа байгаа билээ (26).

Уйгуржин монгол үсгийн дурсгал хэдийгээр XIII-XIV зууны хамаарах ч түүгээр илэрсэн хэл нь нэлээд эрт үеийн монгол хэл онцлогийг тусгасан гэж эрдэмтэд үзэж байна (3:5).

Судлаачид монгол хэлний хөгжлийн түүхийг өөр зууpаа б сага зэрэгтэй боловч үндсэндээ хоёр янзаар ангилж бай Тухайлбал; Б.Я.Владимирцов, Л.Лигети, Д.Төмөртогоо, Шон: нарын зэрэг судлаачид;

Өвөг монгол хэл
Эртний монгол хэл
Дундад үеийн монгол хэл

Орчин үеийн монгол хэл гэж 4 хуваасан (7:78-79, 12:6-35) бс 1955 онд профессор Н.Поппе,

Нийт монгол хэл
Дундад монгол хэл
Орчин үеийн монгол хэл хэмээн 3 ангилжээ (25:15).

Дээрх хоёр ангилалын аль алинд нь "Дундад үеийн монгол х гэсэн бүхэл бүтэн үе шат байгаа юм. Он цагийн хувьд бага с заналт зөрөлдөөн байгаа боловч XIII-XVI зууны үеийг "Дундад үе монгол хэл" гэж барагцаалж болно.

Дундад үеийн монгол хэлний онцлогийг сайтар тусга дурсгалууд гэвэл XIII-XV(XVI) зууны үед хамаарах дөрвөлжин, ар нангиад үсгээр тэмдэглэгдсэн байгаа билээ.

Дөрвөлжин бичгээр Хаад дээдсийн зарлиг, Цавчаал боомтын их, бага бичээс, пайзын бичээс, тамгын бичээс, ном судар, бичиг баримт зэрэг 60 гаруй монгол дурсгал (1,5), араб үсгийн хувьд Мукаддимат ал-Адаб толь, Лайдений толь, Истамбулийн толь гэрэг 6-7 их бага толь бичиг тус тус байдаг (4).

Дундад үеийн монгол хэлний дурсгал дотроос агуулга ач холбогдлын хувьд ч тэр, хэмжээ дамжааны талдаа ч тэр хамгийн далайцтай нь нангиад үсгийн дурсгал мөн гэдэгтэй хэн ч маргахгүй буй за.

Энэ дурсгалаас эн тэргүүнд, 7 мянга гаруй үгийг багтаасан алдарт "Монголын Нууц Товчоон"–ыг дурдах ёстой.

Энэхүү гайхамшигт туурвилыг 1228 юм уу 1240 оны орчим монгол нутагт, монгол хүн , монгол хэл бичгээрээ зохиосон болох нь одоо нэгэнт тодорхой болсон хэмээн үзэж болно.

Анхны тэрхүү эх нь үрэгдээд, эдүгээ Мин улсын эхэн үед Хуо Юань-Гиэ (火原潔), Ма-ша И-хэ (馬沙亦黑) нарын зэрэг эрдэмтэд хятад хүмүүст монгол хэл сургах сурах бичиг, толь бичиг болгох зорилгоор нангиад үсгээр буулгасан эхээс дам дам хуулбарласан хэдэн хуулбар л бидний үед уламжлан иржээ(16,8:1-31,28).

"Монголын Нууц Товчоон"–ы энэхүү хуулбар эх бичиг үндсэн гурван хэсгээс, тухайлбал, монгол эхийн нангиад галиг, үг нэг бүрийн хадмал орчуулга, зүйл тус бүрийн ард дагалдуулсан ерөнхий орчуулгаас бүтдэгийг та бид сайн мэдэх билээ.

Эдүгээ судлаачид Гу Гуань-Чи (顧广圻 1770-1839)-ийн 12 боть хуваасан эх, Е Дэ-Хуй (叶德辉 1864-1927)–н, Цянь Да-Синь (钱大昕 1728-1804)-ий 15 ботит эх зэрэг үндсэн 3 зүйл хуулбарыг баримтлан "Монголын Нууц Товчоон"-ыг шинжилж байна. Энэ гурван эхээс хамгийн алдаа мадаг багатай нь Гу Гуань-Чи-ийн эх хэмээн үздэг билээ.

"Монголын Нууц Товчоон" бол монголын ард түмнээс хүн төрөлхтөний соёлын санд өргөн барьсан гайхамшигт сувд эрдэнэ учраас гадаад дотоодын олон мэргэд удаан жил, зузаан хоног алжаалыг умартан хүч оюунаа шавхсаар асар их ном зохиол туурвисан хийгээд туурвисаар байгаа юм. Энэ бүгдийг энд тоочих арга ч үгүй, бидний зорилго ч бус.

Нангиад үсгийн өөр нэг бүлэг дурсгал гэвэл "И-юй (譯 語) маягийн толь" хэмээгддэг хэдэн зүйл нангиад-монгол толь буй (10).

Эд цөм зүйл хуваасан толь бөгөөд хамгийн анхных нь Хубилай хааны Жи–юаний онд (1264-1294) Чэнь Юань-Лян (陳 元 靚) хэмээх хүний туурвисан "Ши-Линь Гуан-жи (事林廣記) бичигт анх орж нийтлэгдсэн "Монгол И-юй" (蒙古譯 語) буюу "Жи-юань И-юй"

(至元譯 語) толь юм. Энэ толь эдүүгээ хэд хэдэн хувилбара уламжлагдан иржээ.

"Монгол И-юй" толь "И-юй маяг"-ийн нангиад–монг толинуудын анхдагч төдийгүй одоогоор монгол хэл шинжлэ мэдэгдэж байгаа хамгийн анхны орчуулгын толь бичиг болох т туйлын үнэ цэнэтэй юм.

Толь зохиосон зорилгоо зохиогч бээр; *"Тэмдэглэх нь, арв орны (уг нангиад эхээс нь үзвэл "таван зүгийн" гэж байна. Ц.Б) а иргэд үг хэл нэвтрэлцэхгүй, дур шуналаар адил бус ажг Зоригийг ойлгон санааг нэвтрүүлэхийг дорнод орноо ги, өмн орноо сан, өрнөд орноо тидай, умард орноо и (орчуулга) хэмээмү Орчуулга хэмээгч ул ухахуй үг хэлийг тодруулан нэвтрүүлхү хэлмүй.Үг хэл эс нэвтрэлцвээс эрхбиш хэлмэрчээр тодруул нэвтрүүлсний хойно сая санаагаа мэдэлцэн чадмуй. Эдүгээ хян тогтоосон и-юй бичиг нэгэн ботийг нийтэлвэй. Хэрвээ сонирхо аж, болөвсруулан үйлдвээс асууж хариулхуйд аяар дуугарч, то тээглэх төвөггүй болмуй"* (12:127,17:279) хэмээн тодорхойлжээ.

Уул толинд 541 үгийг 22 зүйл хуваан оруулсан байдаг билээ.

Энэ толь нь хэдийгээр нангиад-монгол толь боловч үги бүрэлдэхүүнээс нь үзвэл монгол-нангиад толь гэж хэлмэ санагдана. Учир нь цэвэр монгол ахуйтай холбоотой үг хэллэг ихэ хувийг нь эзэлж байна. Жишээлбэл адууны олон зүйл зүс зүсми нэр томьёо, гэр ахуйн багаж хэрэгсэлийн нэр гэх мэт.

Ийм шинж зөвхөн "Монгол И-юй" толинд бус, "Хуа-и И-юй" то болон бусад нангиад-монгол толийн хувьд ч ажиглагдаж байна. Э нь хятад хүмүүст монгол хэл сургаад зогсохгүй, монголчууд амьдрал ахуй, зан заншлыг тэнсэн мэдүүлэх зорилгоос шалтгаалсан болов уу хэмээн таамаглаж болох юм.

"Монгол И-юй" толиноо "Монголын Нууц Товчоон" болон дар дараагийн толиудад байдаг, одоо хуучирсан боловч түүхэн үгийн с судлалын үүднээс сонирхолтой үгс, эртний монголын арван хо сарын нэр зэрэг чухал агуулга багтжээ.

Уг толь эртний ном учир зарим үг үсэг нэн балархай, монг үгийг нангиадаар галиглсан тогтолцоо нь төдий л нарийн бус, бур солиу бичлэг ихтэй тул одоо хэр нь зарим үг, үсгийг уншиж тайл талаар судлаач мэргэдийн санал онол зөрүүтэй байна (10,17).

"Монгол И-юй" толийг Японы эрдэмтэн М.Ишида, Мажар Л.Лигети, Д.Кара, Өвөр Монголын Шонхор, Ө.Мандах зэрэг хүмү судлан нийтлүүлжээ.

Он цагийн дэсээр дараа нь "Хуа-и И-юй" толь орох бөгөөд б энэ тухай хойно дэлгэрэнгүй авч үзэх болно. Энэ хоёр алда толиос гадна Ван Мин-Хө *(王鳴鶴)* гэгчийн найруулсан "Дэн–та би-жиу" *(登坛必究)* бичгийн 22-р боть дахь и-юй толь (1598) бол

Мин улсын үед (1621) зохиогдсон "Ү бэй-жи" *(武备志)* бичгийн 227-р боть дахь "Бэй-лу И-юй" *(北 卢譯 語)* толь хоёрт төрөл зүйл, үгийн дэс дараа зэрэг нь адилхан нийт 639 үг багтжээ (10).

Мин улсын Бан Лигийн 38-р онд (1610) эмхэтгэн гаргасан "Лу-лүн Сай-луэ бичиг " *(卢龙塞略)*-ийн 19, 20-р ботийн " Орчуулгын бүлэг " *(译部)* бусдаасаа арай өвөрмөц юм.

Учир нь бусдын адил үгсээ тольчлон жагсаагаагүй, харин ар араас нь үргэлжлүүлэн бичсэнээс гадна нэг толгой үгийн хойно түүнтэй холбоо бүхий олон үгийг цувруулан байрлуулсан байдаг байна. Эрдэмтэн Ө. Мандахын тооцоолсноор энэ тольд 1324 үг орсон ажээ (10:385).

Уул тольд "Хуа-и И-юй" зэрэг өмнөх толиудад байдаг үгсээс гадна дараа үеийнх нь монгол хэлний үгийн сан-утгазүйн хувирал өөрчлөлтийг мэдэж болхуйц баримт цөөн бус тохиолддог.

"Хуа-и И-юй" толийн тухай

Дундад үеийн монгол хэлний нангиад үсгийн дурсгал болох толь бичгүүдээс "Хуа-и И-юй" толь нэг талд, нөгөөтэйгүүр, өмнө өгүүлсэн дөрвөн толь хамтдаа нэг бүлэг болно хэмээн хэлж болох юм.

"Хуа-и И-юй" толь хэмжээгээрээ ч, агуулга, ач холбогдлоороо ч "Монголын Нууц Товчоон"-ы дараа орох чухал дурсгал билээ. Энэ толь "И-юй" маягийн толь болохынхоо хувьд бусад тольтойгоо нэг бүлэгт багтахын зэрэгцээ, унших хэрэглэгдэхүүн болох 12 баримт бичигтэйгээрээ "Монголын Нууц Товчоон"-той ижил төстэй юм.

Энэ толь бол и-юй маягийн толиудын дотроос хамгийн том нь төдийгүй, монгол үгийг нангиадаар тэмдэглэсэн арга барилын талаар ч гэсэн хамгийн нарийн зөв тул нэлээд дээр үеэс судлаачдын анхаарлыг татсаар иржээ.

華夷譯語 ("Хуа-и И-юй") гэдэг нь "Нангиад харь хэлний орчуулга үгс" гэсэн үг болох бөгөөд Юань, Мин улсын үед монголоос гадна, япон, солонгос, зөрчид, уйгур, сиам, төвд зэрэг арав гаруй хэлний "Хуа-и И-юй" байсан ажээ.

Өөрөөр хэлбэл, хятад хүмүүст харь хэл сурахад зориулсан толь бичиг, сурах бичиг болж байжээ.

"Хуа-и И-юй" толийг Мин улсын үед "Орчуулгын товчоо"*(四夷馆)*, "Хэлмэрчдийн товчоо" *(會同馆)* хэмээх тусгай байгууллагуудаас эрхлэн гаргадаг байсан байна(23:XII).

"Хуа-и И-юй толь" хоёр дэвтрээс бүрдэх бөгөөд тэргүүн дэвтэр 344 үгийг 17 зүйлд хуваасан нангиад–монгол толь, дэд дэвтэрт 1 захидал харилцааны бичгийг унших хэрэглэгдэхүүн болгон эмхэтгэ оруулсан байдаг. Энэхүү 12 баримт бичгийг зарим судлаачи "Нангиад–монгол харилцааны бичиг" хэмээн нэрлэж тусад нь салга авч судлах нь буй (14,20,21).

Хуа-и И-юй толийн I дэвтэрт;

1. Тэнгэрийн зүйл	19 үг
2. Газрын зүйл	38 үг
3. Цаг улирлын зүйл	24 үг
4. Цэцэг модны зүйл	38 үг
5. Жигүүртэн араатны зүйл	116 үг
6. Орд гэрийн зүйл	17 үг
7. Сав хэрэглэлийн зүйл	71 үг
8. Хувцас хунарын зүйл	26 үг
9. Идээ ундааны зүйл	28 үг
10. Сувд эрдэний зүйл	13 үг
11. Хүн амьтны зүйл	86 үг
12. Хүний үйлсийн зүйл	140 үг
13. Дуу өнгийн зүйл	17 үг
14. Тоо хэмжээний зүйл	35 үг
15. Бие махбодийн зүйл	76 үг
16. Зүг чигийн зүйл	17 үг
17. Үргэлж хэрэглэгддэг зүйл 83 үг гэж 17 зүйл болгон хуваажэ	

12 албан бичгийн эхний 5 нь Хятадын Мин улсын хаанаа дагаар орсон монголчуудад буулгасан зарлиг, 7 нь монгол ноёдоо Мин улсын хаанд өргөсөн бичиг захидал байна.

Үүнд:

А. Мин улсын хаан, дээдсээс монгол ноёдод өгсөн зарлиг,заавар;
1.Ажаширид өгсөн зарлиг
2.Тойн Иринчинсамбууд өгсөн зарлиг
3.Өргөмжлөл
4.Зарлигаар төрийн журганаас Йин Чан-Вэйд өгсөн зарлиг;
5.Зарлигаар төрийн журганаас Анда-нагачуд өгсөн бичиг

В. Монгол ноёдоос Мин улсын хаад, дээдэст өргөсөн бичиг;
1.Самандаширн нарын бичиг
2.Намун хүргэний бичиг
3.Торгочарын бичиг
4.Ширэмүний бичиг

5.Нэхэлэйн бичиг
6.Нэхэлэйн бичиг
7.Мянганы ноён Нангиасын заргын бичиг

"Хуа-и И-юй толь"-ийг зохиосон зохиогч, зохиогдсон он цаг, зориулалтын талаар гэвэл "Мин Ши-лу" (*明實錄*) буюу "Мингийн магад тэмдэглэл" гэдэг олон боть номын "Тайзу хааны магад хууль" хэмээх 141-р ботид 1382 оны 1 сарын 20-ны үйл явдал болгон тэмдэглэсэн нь:

"/Хаан бээр/ бичгийн явдлын хороо (翰林院)-ны асран тайлбарлагч Хуо Юань-Гиэ нарт "Хуа-и И-юй" бичгийг найруулагтун хэмээн зарлиг бұулгав. Хаан бээр, Юаньд уулаас бичиг үсэг байхгүй билээ. Зарлиг заавар буулгахад Гоу чангийн (өөрөөр хэлбэл, уйгурын Ё. Ж.) үсгийг зээлэн монгол үсэг зохиогоод дэлхий дахины хэлүүдийг нэвтрэлцүүлэн авна хэмээн Хуо Юань-Гиэ (火原潔), найруулагч Ма-Ша И-хэ (馬沙亦黑) нарт зарлиг буулгаж тэдний хэлийг хятадаар орчуулуулбай. Тийнхүү одон орон, газар зүй, хүний явдал, бодисын зүйл, өмсөх идэх, эдлэл хэрэгсэл тэргүүтнийг эс бүрдүүлсэн нь үгүй. Дахин "Юаний Нууц Товчоон"-ыг авчран лавлалт болгон үсгүүдийг таслан дуудлага дор нь зохицуулбай.

Найруулан төгөсмөгц жуу зарлан хэвлүүлэн тархаажээ. Түүнчлэн элч нар умард говь орноо одох, ирэхүйд цөм тэдэн лүгээ нэвтрэлцэн чадах болов" (6:69, 2:72-73, 16:452, 11:8-10) гэжээ.

Энэ эшлэлээс үзэхүл "Хуа-и И-юй толь"-ийг "... бараг Хуо Юань-зе, Ма-ша И-хэ гэх мэтийн нэлээд хүмүүс хамтран найруулж орчуулсан байх аа" (11:11) гэсэн Өвөр монголын эрдэмтэн Ө.Мандах багшийн саналыг бид бүрэн дэмжиж байна.

"Хуа-и И-юй" толийг найруулахдаа "...Юаний Нууц Товчооныг авчран лавлалт болголоо" гэсэн өгүүлбэрийг хэрхэн ойлгосноос шалтгаалж судлаачид санал хуваагдаад байгаа билээ. Өөрөөр хэлбэл, "Хуа-и И-юй " толийг найруулах үед "Нууц Товчоон"-ыг авчран нангиад үсгээр галигласан юм уу гэдэг асуудал.

Нака Мичиё, Ван Го-Вэй, Баяр нарын зэрэг эрдэмтэд "Нууц Товчоон"-ы галиг өмнө нь бий болсон гэж үзсэн бол Хятадын эрдэмтэн Чэнь Юань нэгэн алдарт өгүүлэлдээ уул галиг "Хуа-и И-юй"- гээс хожим буй болжээ гэсэн санал дэвшүүлсэн ажээ (8:4-5).

Бид "Хуа-и И-юй" толь болон "Нууц Товчоон" хоёрыг харьцуулан шинжсэний дүнд Чэнь Юаний саналыг дэмжиж байна.

Хуо Юань-Гиэ нар хааны зарлигийг хүлээн авснаас хойш 7 жил махран хөдөлмөрлөсний дүнд "Хуа-и И-юй"-ийг 1389 онд зохион дуусгаж, хэвлэн тараажээ.

Гэвч анхны тэр эх эдүгээ уламжлан ирсэнгүй. Судлаачдийн голлон ашигладаг эх бол 1918 онд Шанхай хотноо "Худалдааны

хэвлэлийн газар" (*商务印书馆*)-аас "Хань Фень лу асарын хов бичиг" (*涵芬楼笈*)-ийн IV түүвэр болгон гэрэл зургаар хэвлэсэн билээ. Ийн хэвлэхдээ Мин улсын үеийн нэгэн барыг ашиглажээ.

1918 оны энэхүү хэвлэлийн эхэнд Лю Сань-Ү (*刘三吾*) хэмэ түшмэлийн бичсэн оршил ба толийг ашиглах дүрмийн тайлб жишээ байдаг. Чухам энэхүү оршлоос л "Хуа-и И-юй"-ийг анх 13 онд хэвлэжээ хэмээн судлаачид мэдэж авсан аж.

Бид "Хуа-и И-юй"-ийг хятад хүмүүст монгол хэл сурах гар авлага болгох зорилгоор найруулсан гэж өмнө нь дурдсан бил Үүнээс гадна бас өөр зорилго байсныг энэхүү "Оршил"-оос мэд болох юм. Иймээс Лю Сань-Ү-гийн оршлыг бүрэн эхээр нь авч үзь

"Түшмэл бодвоос, хятад харийн ялгал болвоос эртнийх бол Богд мэргэдийн хэлэхээр эцэстээ нэг болмуй. Аль ч богд мэргэди сэтгэл нь нэг болгохыг эс хүсэгч нь үгүй буй за. Арга бу хүмүүсийн үг хэл өөр, зан заншил ондоо болохоор байдал нь ар тэгж болохгүй амуй. Хүмүүсийн үг хэл өөр болвоос түүни гэгээрүүлж эс чадмуй. Гэгээрүүлж эс чадваас зан заншил хаана хувирах аж. Тэр заншлаараа байваас ёслол журмыг мэдэхг таван эшийг эс өгүүлмүй . Бичиг харыг үзвээс, эрт язгуураас и байсан болой. Харагч нь нүд ичиж, сонсогч нь чих гутмуй.

Биеэрээ тэр газар хүрэгсэдийг өгүүлэх юун. Дундадын бо хаадаас гадна байгаа бусадчууд ийм л буй за. Өнгөрсөнд Сунги (Сун улсыг зааж байна) хувь заяа төгсч, тэнгэрийн заяа Юа (Юань улсыг хэлж байна)-ий эзэнд болж Дундадыг эзэрхэв. Тэдн заншил нь морь унаж харвах намнах, алж дайтахдаа сайн, хар ерөөс үсэг бичиггүй болой. Зар зарлиг буулгахуйд үсэг бичиг бөгөөс дамжуулж эс чадах учраас Гоу чангийн үсгийг (уйгур үсгі зааж байна) зээлж өөрийнхөө хэв дүрэм болговой. Сүүлдэж ир дахин төвд тойнд зарлиг буулгаж монгол үсэг зохиолгож, don гаднад авиаг сургасан боловч түүний утгыг цөм гүйцэд үл мэдм Тэгэхдээ, хишиг сүр хууль зарлигаас болоод 93 жил үргэлжлэх зөвхөн хятад үгийг хүндэтгэвч гагцхүү харь бусдыг л бичмүй. Үі сэжиглэх сэргийлэх сэтгэл байсан ажгуу. Бишрэх нь хаан тэнгэрийн тэмдэгтэйөө заяаг хүлээж хятад харийн эзэн болө Ойрд, дөрвөн далай нэгэн гэр болж хучууд (胡人 монголчуудыг хэ байна.) бүгд дагавай. Бодвоос, тэнгэр ард иргэнийг төрүүлж, э түшмэлийг бүй болгодог аж. Сургахуйд ялгал үгүй. Сургах эрхгүй үг хэлийг нэвтрэхээс эхэлмүй. Үг хэл нэвтэрмэгц үі бичгийг нь эс өөрчилвөөс үл болмуй. Тэдний бичгээр нэгэн үсг бичихэд хэд хэдэн тэмдэг хэрэглэж, ахин дахин холбон хэлхэж утгыг илтгэмүй. Яршиг түвэг нь маш их болой. Харин Дундаа тоо томшгүй үсэг, бүрэн төгөлдөр авиаг ашиглаваас түүн орчуулахад эс хүрэлцэх нь үгүй буюу.

Зөвхөн аль алиныг нэвтэрхий мэдэгчийг олоогүй л төдий буй за. Бичгийн мэргэдийн хүрээлэнгийн тайлбарлагч Хуо Юань-Гиэ (火源洁) умард говийн үгсаатан боловч хятад газар төрвэй. Өөрийн үсэг бичгийг мэдэхээр түүн лүгээ мөр зэрэцзгч ховор. Дундадын дөрвөн номд нэвтэрхий бөгөөд түүний утгыг бүр мэдмүй. Тэгээд хятад үсгээр монгол үгийг орчуултугай хэмээн зарлиг болвой. Тав гурвыг овоолон холбомогц тэдгээр үсгийг сая бүртгэмүй. Харгуулан тайлбарламагц түүний утга сая тодорхой болмуй. Авиаг зохицуулваас аяар хэрэглэж бүгдийг хангаж чадмуй. Үүнд эмхэтгэн хэвлэн нийтэлсэн ажгуу. Түшмэлийн ухахаар, таван зүгийн хүмүүс, үг хэл нэвтрэлцэхгүй, дур хүсэл бас ондоо болохоор их Жеү-гийн үед Сян-Сюй (象胥 орчуулга хийх түшмэл) хэмээгч түшмэл томилж, хэн алиныхаа ухааныг ололцож авай. Эдүгээ дэлхий дахин үсэг бичиг, зам хэмжүүр адилхан болвой. Хаан, хэнийг ч алагчлахгүй сэтгэлийг барьж, энэхүү бичгийг эрхлэн, хамаарч байх нь үг хэлийг нэвтрүүлж, зориг санааг туулуулж, ёслол хөгжим гэгээрэл дөрвөн зүгт хүрээд харш саадгүй болгохын туст болой. Хятадаар харийг хувируулах ёс учир яг үүнд буй амуй за. Түүнийг өчүүхэн тус нэмэр хэмээн хэрхэн өгүүлж болох аж. Хун-у-гийн 22-р он (1389 он)-ы өвлийн 10-р сарын 15-ны өдөр. Бичгийн мэргэдийн шүэ-ши (学士) Фэн-И газрын дайбан түшмэл (大夫) бөгөөд зүүн Чунь Фан (左春坊)-гийн зүүн Зань-шань (左赞善)-ий түшаалыг хавсран гүйцэтгэгч Лю Сань-Ү (刘三吾) бээр хичээнгүйлэн оршил бичвэй" (11:32-34, 12:721-724). (Нангиад эхийг I хавсралтаас үзнэ үү).

Энэ "Оршил"–оос үзвэл ёс мэдэхгүй, ичиж ой гутам бүдүүлэг монголчуудыг өөрийн төгс боловсронгуй хятад хэл бичгээрээ дамжуулан гэгээрүүлж, улмаар "...хятадаар харийг хувируулах ёс" буюу монгол болон бусад харь үндэстнүүдийг хятадчлан уусгахыг санаархсан хятадын ихэс дээдсийн хорон муу санаа, бүтэшгүй мөрөөдлийг энэ түшмэл ил задгай тунхаглажээ. Үүний тулд бидний монгол болон дөрвөлжин бичгийг муулан гутааж, хятад үсгийг бүхний дээр тавьж байна .

Ийнхүү "Хуа-и И–юй" толийг найруулсан цаад улс төрийн санаархал нь монголчуудыг хятад болгон уусгах далд санаанд оршиж байсан ажээ.

"...Бид Хятад үсгийн сайн муугийн тухай энэ тэр гэж хэлэх санаа үгүй байна. Монгол үсэг бол хятад үсгээс давсан авианы үсэг болохыг орчин үеийн шинжлэх ухаан нэгэнт нотолжээ" (11:17-18) гэсэн профессор Ө.Мандахын үгийг энд эшлэмээр санагдана.

Лю Сань-Ү-гийн бичсэн "Оршил" дахь нэг чухал зүйл бол "Хуа-и И-юй" толийг зохиогчдын нэг Хуо Юань-Гиэгийн тухай мэдээ юм. Энэ хүний амьдрал үйлсийн талаар одоо болтол үүнээс өөр баримт олдоогүй байна.

"Оршил"-д дурдсанаас үзэхүл, Хуо Юань-Гиэ бол Хятада, төрсөн монгол хүн бөгөөд монгол, хятад хоёр хэл бичиг төг нэвтэрсэн эрдэмтэн байсан ажээ.

1389 онд "Хуа-и И-юй" толийг анх хэвлэхэд толийн өмнө Лю Сань Ү-гийн "Оршил" болон "Тайлбар жишээ" байсан ажээ. Гэтэ 1918 онд хэвлүүлэхдээ Сунь Юй гэдэг хүн "Төгсгөлийн үг" бичсэ байна. Энэ "Төгсгөлийн үг"-д зарим чухал баримт байх тул Ө.Манда багшийн орчуулгаар сийрүүлбэл;

<<"Хуа и И юй" дотроо боть хуваахгүй болой. Мингий төрийн Хун У-гийн 12-р онд (Лю Сань Ү-гийн "Оршил"-д Хүн-Ү-гий 22-р он гэж буй. Орчуулагч) Бичгийн мэргэдийн хүрээлэнгий тайбарлагч Хуо Юань-Гиэ (火源洁) орчуулж, Жин Чан (经厂) хэмээ хэвлэлийн газраас хэвлэсэн дэвтэрт Лю-Сань-Ү (刘三吾)-гий бичсэн оршил ба ерөнхий тайлбар (凡例) зургаан зурвастай байе Эхний хэсэг нь тэнгэрийн утга гэх мэтээр үсгүүдийг 17 айма хувааж, сүүлийн хэсэг нь Ажашири зэрэг зарлиг айлтгалын бичи 12-ыг багтаажээ. Тодорхойлох нь, Хуо Юань-Гиэ уул нь Юан улсын түшмэл хүн байв. Юаний үед солонгос, рюкю (Японы баруу өмнө байгаа олтирогууд дээр байсан эртний улс. Орчуулагч), япон аннам (安南 одоогийн Вьетнам. Орчуулагч), Жань чен (占城 эртни улсын нэр, одоогийн Вьетнамын өмнө хэсгээр тогтнож байгаа 17-р зууны сүүлчээр сөнөв. Орчуулагч), сиам (одоогийн Тай улс Орчуулагч), монгол (鞑靼), уйгур, төвд, сартуул (Хятадаар 回回 персийг заажээ. Орчуулагч), малага (14-16-р зууны үед тогтно байсан Малайн эртний феодалын вант улс. Орчуулагч), зүрчи бай и (白夷) зэрэг 13 улсын и-юй (译语 орчуулга үгс) байжээ. Юани үед түүвэрлэсэн дэвтэр байсан бөгөөд түүний нэр нь мөн "Хуа-и И юй" гэж байв. Гу (顾) овогтын "日知录" хэмээх зохиолын илүү ботийн 4-р ботид хэлснээр эрт өмнө Юань (Монголчуудыг заа буй. Орчуулагч) болбоос үсэг бичиггүй , Гоу чан үсэг (уйгур үсэг) ийг зээлж монгол үсэг зохиож дэлхий дахины хэлнүүдтэ нэвтрэлцэж байв гэнэ. Эдүгээ Бичгийн мэргэдийн хүрээлэнгий тайлбарлагч Хуо Юань-Гиэ ба найруулагч Машийг зэрэг хүмүүс зарлиг буулгаж хятад үгээр тэдний хэлийг орчуултугай гэ Тэгэхдээ Юаний Нууц Товчооныг лавлалт болгон, үсгүүдий холбож, авианууды зохицуулж бүтээв. Зарлигаар хэвлэ тархаажээ. Түүнээс янагш элчид умард говиор нааш цааш явахда учир явдлыг бүр нэвтэрхий мэдэх болвой. Энэ даруй тус ном боло Гэвч одоогийн олдсон дэвтэрт Машийгийн нэр байхгүй. Маший хэмээгч баруун газрын одон орны номыг орчуулагч бөгөөд монго бичгийг давхар мэддэг байжээ. Жин чан хэвлэлийн газрын гаргаса номын гарчигт нэмж зассан "Хуа-и И-юй" арван нэгэн дэвтэр гэ

бас буй. Үүнээс үзэхэд, Мингийн төрийн үед өрөөсөө 2 зүйлийн дэвтэр байв .

Гү овогтын олж үзсэн нь тэрхүү нэмж зассан дэвтэр аж. Үг үсэг хоёрыг зэрэгцүүлэн тавьсан байв. Түүхийн зохиолын хувьд авч хэлбэл зөвхөн зохиолын утгын орчуулгыг хийж, найруулан бичихийг хангаваас болох буй за. Түүний дамжин орчуулагдсан яршиг түвгийг эрхгүй асуух хэрэг юун болой. Орчуулгын зохиолын хувьд авч хэлбэл эрхгүй уг зохиолыг мэдмэгц сая түүний утгыг олмуй. Юаний дэвтрийг үндэслэн сийлсэн Юань улсын Нууц Товчоон Сян Жүн (Ху-нан мужийн газрын нэр. Орчуулагчаас)-гээс нэгэнт олдов. Юань улсын үеийн барын Хуа-и И-юй хийгээд Мин улсын үеийн хүн Мао Ень (毛寅), Ли Гуан Юань (李广元) зэрэг хүмүүсийн хийсэн арван улсын и-юй бичиг цөм олдохгүй болов. Гагцхүү тус дэвтэр л бүрэн бүтэн байх болохоор бачим яаруу хэвлэн тархаж, орчуулгын ажилд сэтгэл тавигч орчлонгийн хүмүүс лүгээ хамтаар нандигнан хадгалсугай хэмээмүй. Шар морин жил (1918)-ийн хаврын өдөр У-си (无锡) газрын Сунь Юй (孙毓) гаргалгыг бичвэй>> (11:41-43). (Нангиад эхийг V хавсралтаас үзнэ үү).

Үүнээс хэдэн зүйл тодорхой болж байна.

Үүнд:

1."Хуа-и И-юй"-ийн 1389 оны анхны хэвлэлд боть хуваасан зүйл байгаагүй бөгөөд 1918 онд дахин хэвлэхдээ дээд, доод хоёр дэвтэр болгожээ.

2.Хуо Юань-Гиэ бол Юань улсын түшмэл байж, дараа нь Мин улсад дагаар орсон бололтой.

3.Юаний үед солонгос, рюкю, япон, аннам, жан чен, сиам, монгол, уйгур, төвд, сартуул, малага, зүрчин, бай-и гэсэн 13 хэлний "и-юй" толь байжээ.

4.Сунь Юй энд "Мингийн магад тэмдэглэл"-д гарах "Хуа-и И-юй" толь зохиосон тухай мэдээг Гү овогт гэгчийн бичсэн "日知录" хэмээх номоос дам авч оруулжээ.

5.Ма-ша И-хэ-гийн талаар мөн л мэдээ сэлт ховор байдаг. Гэтэл энэ "Төгсгөлийн үг"-д дурдсанаар энэ хүн баруун газрын одон орны ном орчуулдаг бөгөөд монгол хэл бичгийн боловсролтон байжээ.

Одоо "Хуа-и И-юй" толийн хэдэн зүйл барын талаар товч өгүүлье. Үүнд:

1.Анхны хэвлэл. Энэ нь 1389 оны хэвлэл бөгөөд одоо үрэгдэж үгүй болжээ.

2.Өвөр Монголын судлаачид "Нань-хуа дэвтэр" хэмээн нэрлэдэг бидний тухайлан судалж буй 1918 оны бар. Энэ нь анхны хэвлэлээс гарал ирэлтэй бололтой.

3.Уйгуржин дэвтэр. Энэ хэвлэлд өмнө хойноо ямар ч оршил, тайлбар, төгсгөлийн үг байдаггүй, Нань-хуа дэвтэртэй бараг адил бөгөөд дээрээс нь уйгуржин монгол үсэг нэмж бичээд барлажээ. Энэ хэвлэл Бээжингийн номын санд хадгалагдаж байдаг гэнэ. Манайд ч хувь хүнд байхыг нь харсан удаатай.

Энэ хувилбар Уйгур хэлний "Хуа-и И-юй"-ийн нэгэн адил эхний мөрөнд монгол үгийн нангиад галиг, удаад нь хятад орчуулга, эцэст нь уйгуржин үсгээр бичсэн байдаг билээ.

4.Хуулбар дэвтэр. Энэ бол 4 боть бөгөөд эхний боть нь уйгуржин дэвтэртэй яг адил, 2-р боть нь нангиад–уйгур орчуулга үгс, 3-р боть нь монгол-хятад "Хуа-и И-юй"-ийн өөр нэг хувилбар, 4-р ботид нангиад-монгол, нангиад-уйгур, нангиад-зөрчин хэлний орчуулга үгсийг хольж дэвтэрлэсэн байдаг ажээ. Энэхүү 3,4-р дэвтэрийг Х.Лувсанбалдан нар хэвлүүлсэн билээ(9).

5.Гуо-хуа дэвтэр хэмээн товчлон нэрлэдэг бас нэгэн иж "Хуа–и И-юй" байдаг байна (10:156-159).

Энд дурдсан 5 зүйл хувилбар бол зөвхөн Хятадад байдаг бар хэвлэлүүд ажгуу. Гэтэл Тайвань, Япон болон Өрнөдийн номын сангуудад нэлээд олон зүйлийн "Хуа-и И-юй" толь байдаг сураггай.

Бид "Хуа-и И-юй" толийг "Монголын Нууц Товчоон" болон "Монгол И-юй" тольтой галигласан системийнх нь үүднээс харгуулан ажиглахад ч тэр, нөгөөтэйгүүр "Хуа-и И-юй" толины хувилбаруудыг өөр зуур нь харьцуулан судалсан эрдэмтдийн бүтээлийг (12:721) үзсэн ч тэр хамгийн шилдэг сайн нь судлаачдын "Хань-хуа дэвтэр" хэмээн товчлон нэрлэдэг 1918 оны барын хэвлэл болж байна.

"Хуа-и И-юй " толь нь бусдаас давуу болох талаар хэдэн жишээ үзүүлье.

Үүнд ;

Үсгийн зүүн дээд өнцөгт " 丆 " үсгийг жижгээр бичиж "ǀ" дэвсгэрийг, "𠂇" үсгийг мөн ийн бичиж "r " гийгүүлэгч, "中" үсгийг тийн бичиж хэлний гүн угийн хамжих "q " авиаг тус тус тэмдэглэдэг.

Жишээлбэл ;

п д э в с г э р и й г ǀ-э э р д у у д а х:

迭		巴	
衣	de'el	爪	ba'ul
丆延		丆温	

Iдэвсгэр нэмж дуудах:

薛 孛
bo'ol
婢 丁斡

г–ээр дуудах:

纳 忽
松 舌刺 narasun 羔 舌里 quriqan
孫 罕

q-аар дуудах:

中合 阿
春 不 qabur 叔 巴 abaqa
儿 (habur бүс) 中合

Түүнчлэн монгол хэлний дэвсгэр үсгийг "Монголын Нууц Товчоон"-ы нэгэн адил үеийн баруун доод буланд жижиг үсгээр тэмдэглэсэн нь буй. Жишээ нь :

中合
牌 勒 qalqa
中合

Гэтэл "и-юй" маягийн бусад толинд ийм нарийн тэмдэглэгээ байдаггүй.
Жишээ нь , " Монгол и-юй" толиноо ;

纳 忽
日 刺 nala 雨 刺 hula
(nara) (qura)

忽
井 都 hudu 珠 速 subu
(quduq) 子 不 (subud) гэх мэт.

"Хуа-и И-юй" толинд "Монголын Нууц Товчоон" болон дунда үеийн монгол хэлний дурсгалд тохиолддог эдүгээ хэрэглэгдэх больсон олон үг байхаас гадна "Нууц товчоон"-д байддаггүй ba'u badinga, kerbel, si'idam, orbu'ur, yongqot зэрэг 400 гаруй үг бий.

Ийм ч учраас дундад үеийн монгол хэлний үгийн санг судлахд чухал нэгэн гэрч баримт болдог билээ.

"Хуа-и И-юй" толийг судалсан байдал

Польшийн авъяаслаг монголч эрдэмтэн М.Левицки (1908-195 1949 онд "XIV зууны үеийн нангиад галигаар бүхий монгол хэл, 138 оны Хуа-и И-юй толь" хэмээх номыг франц хэлээр нийтлүүлжээ (18 Энэ нь дэлгэрэнгүй удиртгал, монгол үгийг нангиадаар галигласа тухай нарийн нягт шинжилгээ, уул тольд орсон бүх ханз үсгий жагсаалт, "Хуа-и И-юй" толийн монгол хэлний авиа зүй, үг зүй судалгаа (5-132-р тал), 12 баримт бичгийн латин галиг (135-146-тал), 1918 оны барын хэвлэлийн гэрэл зургийн хуулбар (149-225-тал) зэргийг багтаасан томоохон бүтээл болсон юм.

Энэ ном бол "Хуа-и И-юй" толийн шинжилгээ , ялангуяа хэлни судлалын талаар гарсан хамгийн сайн зохиолын нэг гэж бид үзэ байна.

Профессор М.Левицки цаг бусаар таалал төгссөн явда цаашдынх нь судалгааг харамсалтайгаар тасалдуулжээ.

1959 онд уул толийн үгийн цэсийг Рената Коон (Renata Kohn хэмээх судлаач хэвлүүлжээ (19).

Уул бүтээлд нангиад эхийн латин галиг, мөнхүү үгийн фран орчуулга, хятад үгийн дуудлагыг латинаар тус тус тэмдэглэн, 191 оны хэвлэлийн хуудасны дугаарыг заажээ.
Жишээ нь :

"...biliktü 'prudent, sage' (tche you) a 11 v "(19:19) гэх мэт. Гэв энэ бүтээл үг үсгийн алдаа ихтэй болсныг олон судлаач шүүмжлэ бичсэн юм.

Эдгээр шүүмжээс ноцтой нэгийнх нь талаар дурьдвал, Р.Коо (R.Kohn) номынхоо "Өмнөх үг"-д "...Le professeur Janusz Chmielewsk a bien voulu se charger de la révision de la partie chinoise de ce lexique (19:5) ("Энэ толины хятад хэлний хэсгийг профессор Януш Хмиелевски сайн дурааараа хянан засварлах болсон юм") гэж бичжэ

Гэтэл мөн 1959 онд Польшийн Дорно дахины судлалын сэтгүүлд профессор Я.Хмиелевски эсэргүүцсэн шүүмж нийтлүүлжээ.

Уг шүүмжинд дурдсанаар бол, 1957 оны II сард Польшийн ШУА–ийн Дорно дахиныг судлах Хороо, хатагтай Р.Кооны бэлдсэн үгийн хэлхээний талаар саналаа хэлэхийг түүнээс хүсчээ. Тэр үед Я.Хмиелевски уг номыг бүгдийг нь үзэх боломжгүй байсан учраас машиндсан зохиолын энхий хоёр хуудсыг үзэж зөвхөн эхний хуудаснаас нь л олон тооны алдаа илрүүлж, ийм байдлаар хэвлэж болохгүй гэсэн саналаа тус Хороонд амаар болон бичгээр илэрхийлж, үүнээс хойш уг зохиолтой ямар ч холбоогүй байсан гэдгээ хариуцлагатайгаар мэдэгдсэн байдаг.

Тэрбээр уул шүүмждээ Р.Кооны хэвлүүлсэн номын энд тэндээс 20 хуудас сонгон хятад хэлний талаас нь шалгахад илэрсэн нь энэ хэмээн олон тооны алдаа мадаг жагсаан үзүүлж, уул бүтээлийг хятад хэлний үүднээс ашиглах бол маш болгоомжтой хандахыг сануулжээ(13:101-104).

Профессор И. де Рахевильц "... Malheureusement, ce travail n'est pas utilisable à cause du grand nombre d'erreurs et d'omissions qu'il renferme. (23:VIII) ("...Орхисон гээсэн зүйл болон алдаа мадаг маш их учраас энэ бүтээлийг (Р.Кооны 1959 оны " Үгийн цэс "-ийг хэлж байна. Ё.Ж.), харамсалтай нь , ашиглах боломжгүй юм") хэмээн бичсэн буй.

1952 онд Германы нэрт монголч, нангиадач, профессор Э.Хэниш (1880-1966) "14-р зууны сүүл үеийн нангиад-монгол баримт бичиг" хэмээх номдоо уг толийн II дэвтрийг судалсан юм (14). Энэ бүтээлд томоохон өмнөх үг (3-20-р тал), эх бичгийн латин галиг (21-26-тал) герман орчуулга, 1918 оны эхний фото хуулбар, тольд хэрэглэгдсэн ханз үсгийн жагсаалт (33-34-р тал), нийт үгийн цэс (49-58-р тал) зэрэг зүйл оржээ.

Гэвч энэ бүтээлд үг үсэг хаясан, буруу уншсан зэрэг дутагдал байхаас гадна латин галиг нь тухайн үеийн монгол хэлний онцлогийг бус, харин орчин үеийн Бээжин аялгууны дуудлагыг илүү харгалзсан сул талтай.

Профессор Э.Хэниш бээр 1957 онд "Нангиад-Монгол толь I: Хуа-и И-юй" хэмээх ном гаргажээ (15). Энэхүү бүтээлд товч өмнөх үг (5-7-р тал), "Хуа-и И-юй" толийн галиг (9-33-р тал), бүх үгсийн цагаан толгойн дэсээрх жагсаалт (32-37-р тал) зэрэг орсон буй.

Толь бичгийн хэсгийн а) уйгуржин монгол эхийн галиг, b) "Уйгуржин дэвтэр"-ийн нангиад галиг, c) 1918 оны барын нангиад галиг, d) уг нангиад эх, e) герман орчуулга гэсэн таван багана болгожээ. Үүнээс жишээ үзүүлбэл:

"1.Himmelskunde

a	b	c	d	e
tngri	tenggili	tenggiri	天	Himmel
naran	nalan	naran	日	Sonne"

гэх мэт. Зохиогч мөн л өөрийн өвөрмөц галигаа хэрэглэв.

Мажарын нэрт монголч, академич Л.Лигети (1902-1987) 1972 онд "Пагвагийн үсгийн дурсгал. Нангиад галигаар бүхий албан бичгийн зүйл" номынхоо дэд хэсэгт "Хуа-и И-юй" толийн 12 баримт бичгийн маш нарийн нягт галиглан хэвлүүлсэн байдаг(20). Академич Л.Лигети дараа жил нь уул номныхоо бүх үгийн цэсийг мөн нэрээр хэвлүүлэв(21). Л.Лигетийн энэ хоёр бүтээл бол "Хуа-и И-юй" толийн II дэвтрийг судлахад томоохон хувь нэмэр оруулсан болой.

Бельгийн алдарт монголч эрдэмтэн А.Мостэрт (1881-1971) "Хуа-и И-юй" толийг олон жил судалж үнэ цэнэтэй бүтээл туурвисан боловч ,ажлаа хэвлүүлж чадалгүй таалал төгссөн ажээ. Түүний бүтээлийг Австралийн нэрт монголч эрдэмтэн профессор И. де Рахевильц эрхлэн хэвлүүлсэн юм. Уул бүтээлийн тэргүүн дэвтэр 1977 онд "Хүн-ү"(1389)-гийн үеийн "Хуа-и И-юй" толины монгол хэрэглэгдэхүүн " нэрээр гарсан бөгөөд профессор И. де Рахевильц уул номд энэ толинд холбоо бүхий асуудлыг машид нарийвчлан авч үзсэн томоохон "Удиртгал" (VI-XXIII) бичиж, дараа нь "Хуа-и И-юй" толины 12 бичгийн латин галиг (1-14-р тал), франц орчуулга (15-32-р тал), "Хуа-и И-юй"-ийн дээд, доод дэвтэрт багтсан бүх үгийн толь (33-111-р тал), монгол хэлний нөхцөлийн хэлхээс (112-114-р тал), хятад нэр томьёо, цол хэргэм, оноосон нэрийн хэлхээс(115-116-р тал) "Хуа-и И-юй" толины үгсийг монгол бичгээр сэргээсэн үгийн цэс (117-127-р тал), монгол үгийг францаар орчуулсан франц үгийн цэс (128-143-р тал) зэргийг багтаав.

А.Мостэртийн хийсэн толийн жишээг үзүүлбэл: "...ha'aljin araignée 蜘蛛 I 6v,3 (tr. 哈阿里貞 ha'alijin) [ayalja, ayaljan, ayalji, ayaljin]' (23:59).

А.Мостэртийн энэ бүтээл бол жинхэнэ эрдэм шинжилгээний ажил гэж юу байдгийг ёсоор нь харуулсан туурвил болжээ. Уул номын II дэвтэр буюу "Тайлбар"-ыг 1995 онд профессор И.де Рахевильц хэвлүүлсэн аж.


Харамсалтай нь энэ номыг бид өнөө хир олж үзэж чадаагүй тул хэлэх үг алга(24).

Манай нэрт эрдэмтэн Х.Лувсанбалдан (1925-1993) Хөх хотын их сургуульд монгол хэлний багшаар уригдан ажиллаж байхдаа профессор Боушиантай хамтран <<"Хуа-и И-юй" толь бичгийн зарим хэсэг>> хэмээх цуврал өгүүлэл нийтлүүлжээ (9).

Зохиогчид энэ бүтээлийнхээ оршилд дундад үеийн монгол хэлний дурсгалуудын тухай, "Хуа-и И-юй" толийн хувилбарууд, тэдгээрийн ялгааны тухай, уул номд монгол үгийг галигласан

онцлогийн тухай хэд хэдэн товч боловч сонирхолтой баримтыг өгүүлж, хожим нь профессор Ө.Мандах өөрийн бүтээлдээ "Хуа-и И-юй" толийн 4-р хувилбар буюу "Хуулбар дэвтэр" хэмээн нэрлэсэн (10:158-159) 4 боть зохиолын 3, 4-р ботид багтсан хэрэглэгдхүүнийг сэргээн хэвлүүлсэн нь нэн бахдууштай хэрэг. Жишээ үзүүлбэл;

" 天文

бичгийн хэл	хятад тэмдэг	хятад тэмдгийн галиг	хятад тэмдгийн дуудлагын галиг	хятад орчуулга	уйгуржин бичгийн галиг
	升革八	shinggeba	shinggeba	消	singgebe

"(9:21)

Дээрх хоёр эрдэмтний бүтээлийг хожмын хүмүүс олж үздэггүй юм уу, эсвэл "мартчихдаг" юм уу, энэ талаар огт дурддаггүй нь харамсалтай.

Манай эрдэмтэн Ж.Надмид багш 1967 онд хэвлүүлсэн номдоо "Хуа-и И-юй толь" гэсэн хэсэг оруулж, уул толийн учрыг бүрэн таниулж, хэлнийх нь онцлогийг товч дүгнэхийн зэрэгцээ, II дэвтрээс "Торгочарын бичиг"-ийг Э.Хэнишийн номоос авч оруулан, үг хэллэгийн товч тайлбар үйлдэж, орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн нь буй(2).

Харин Ж.Надмид багш "... монгол хэлэнд холбогдох Хуа-и И-юй гурван дэвтэр байдаг ажээ. Үүний сүүлийн 2 дэвтрийг 1959 онд Х.Лувсанбалдан, А.Бошиан нар өөр монголын "Монгол хэл, зохиол, түүх" сэтгүүлд хэвлүүлсэн билээ" (2:73) хэмээн тэмдэглэжээ.

Өөр монголын эрдэмтэн Ө.Мандах 1995 онд " Монгол И-юй бичиг" хэмээх томоохон бүтээлдээ бидний дээр авч үзсэн И-юй маягийн таван толийг анх удаагаа нэг бүрчлэн судлан хэвлүүлсэн нь монгол судлалын ертөнцөд тэмдэглүүштэй үйл явдал мөн.

Зохиогч номынхоо оршилд уул таван толийг хэвлүүлсэн зарчмаа дэлгэрэнгүй танилцуулав(10:1-34).

Толь бичгүүдийг хэвлүүлэхдээ тус бүрийн өмнө түүнд холбоо хамаа бүхий асуудлыг нэг бүрчлэн судлан шинжилсэн байна.

Уул номын 151-275-р талд 1918 оны бар хэвлэлийг үндэслэн "Хуа-и И-юй" толийг судалжээ. Толийн өмнө түүний онцлог, ач холбогдол хувилбар зэргийг авч үзжээ(10:153-167).

Толийг хэвлүүлэхдээ эхний мөрөнд уг хятад эхийн сийрүүлэг, 2-р мөрөнд латин галиг, 3-р мөрөнд уйгуржин монгол үсгийн сийрүүлэг, 4-р мөрөнд одоогийн монгол үсгийн бичлэг буюу зарим хуучирсан үгэнд тайлбар хийжээ. Мөн зарим үгэт "зүүлт" дагалдуулав.

Жишээлбэл:

"

石 赤剌溫 

" гэх мэт (10:173

Бусад толийг ч мөн ийм маягаар хэвлүүлжээ.

Тэрбээр 1998 онд "Хуа-и И-юй" хэмээх ном хэвлүүлж эн толийн дэд дэвтэр дэх 12 баримт бичгийг нягтлан судалсан нь мөн бахдууштай бүтээл болсон байна.

Уг номын "Удиртгал"-д "Хуа-и И-юй" тольтой холбоо бүхи асуудлыг нэн дэлгэрэнгүй бөгөөд нарийн хянамгай судалжээ.

(11:6-27

Энд нэг анхаарууштай зүйл гэвэл, профессор Ө.Манда "...манай улсын, ялангуяа баруун зүгийн хятад хэлтэй судлагч на нэлээд эртнээс "Хуа-и И-юй"-г анхааран судалсаар иржээ. Тэгэхд "Хуа-и И-юй"-гийн дээд дэвтэр, тухайлбал, "Хуа-и И-юй"-гийн тол бичгийн хэсгийг анхаарснаар илүү шиг, харин үргэлжилсэн үгэ тэмдэглэсэн доод дэвтрийг төдий их судалсангүй. Жишээлбэ Германы эрдэмтэн Хэниш, Японы эрдэмтэн Ямазаки зэрэг хүмү "Хуа-и И-юй"-гийн толь бичгийн хэсгийг судалж, бүр тусгай өгүүлэ нийтэлж өнгөрчээ" (11:6) гэж бичсэн нь профессор Э.Хэниший 1952 оны бүтээлийг (14) олж үзээгүйгээс ийнхүү дүгнэсэн агаа А.Мостэртийн 1977 оны номыг ч бас үзээгүй болоптой.

Мөн "...Бидний мэдэж байхаар Америкийн нэрт монгол эрдэмтэн Ф.В.Кливезээс "Харвардын Азийн эрдэм шинжилгээни сэтгүүл" ("Harvard Journal of Asiatic Studies" сэтгүүлийг хэлж байн Ц.Б.) дээр "Нангиад монголын харилцааны бичиг" хэмээх нэгэ өгүүлэл нийтэлж "Хуа-и И-юй"-гийн доод дэвтрийг тусгайла судалжээ" (11:7) гэж бичсэн нь эндүүрсэн хэрэг буй за.

Профессор Ф.В.Кливез (1911-1995) ийм зохиол о нийтлүүлээгүй бөгөөд уул толийг тусгайлан судалж ч байгаагү билээ.

Харин профессор Ө.Мандах, Америкийн эрдэмтэн Х.Серрк (Henry Serruys)-ийн "The Dates of the Mongolian Documents in th Hua-I I-Yu" (H.J.A.S.vol.17, №3-4.1954. pp.419-427) хэмээн өгүүллий андуурсан байж магадгүй юм.

Үүний дараагаар уул тольд Лю Сань-Үгийн бичсэн "Оршил"-ын нангиад эх (11:28-31), түүний монгол орчуулга (11:32-34), "Ерөнхий тайлбар"-ын хятад эх бичиг (11:35-36), түүний орчуулга(72:37-38), уг толийг 1918 онд хэвлүүлэхдээ зохиолын төгсгөлд Сунь Юй гэдэг хүний бичсэн "Гаргалга"-ын хятад эх бичиг (11:39-40), түүний орчуулга (11:41-43) зэргийг оруулжээ.

Ө.Мандах багш дараа нь зохиолын гол хэсэг буюу 12 баримт бичгийг 1. уг бичгийн нангиад эх, 2. латин галиг, 3. монгол үсгийн сийрүүлэг, 4. үгсийн тайлбар, 5. тодорхойлолт (энэ хэсэгт уг бичгийн түүхэн утга учрыг тодруулан тайлбарлажээ.) 5. ерөнхий орчуулгын нангиад эх, 6. түүний орчуулга гэсэн дэс дараатай үйлджээ. Энд нэг анхааруушталй нь 5,6-р хэсэг зөвхөн эхний 5 бичиг буюу Мин улсын хаанаас монгол ноёдод илгээсэн бичигт л хамаарах юм. Учир нь монгол ноёдоос Мин улсын хаанд өргөсөн 7 бичиг захидалд ерөнхий орчуулга байдаггүй билээ.

Төгсгөлд нь "Тайлбар хийсэн үгсийн хэлхээс" (11:373-385), "Товчилсон үг, хэрэглэсэн тэмдэг" (11:386-387), "Ашигласан сурвалж бичиг материал бөлон лавлалт болгосон судалгааны бүтээлүүд" (11:388-389) зэргийг хавсаргажээ.

Профессор Ө.Мандахын энэхүү 2 ном бол монгол угсаатны эрдэмтнээс "И-юй маягийн толь"-ийг анх удаа бүрэн цогцоор нь судалсан хамгийн дорвитой, хамгийн том бүтээл мөн хэмээн дүгнэж байна.

Бидний олж үзсэнээр "Хуа-и И-юй" толийг судлан хэвлүүлсэн хамгийн сүүлийн үеийн бүтээл бол Японы Тохоку их сургуулийн профессор Х.Курибаяшийн 2003 онд Сендай хотноо хэвлүүлсэн <<"Хуа-и И-юй"-гийн монгол үг, нөхцөлийн хэлхээс >> хэмээх ном юм(29).

Зохиогч уул номдоо дэлгэрэнгүй удиртгал бичиж, "Хуа-и И-юй" толийн дээд , доод дэвтрийн латин галиг, уг эх, хоёр дэвтэрт багтсан бүх үг, нөхцөлийн хэлхээсийг тус тус нийтлүүлсэн байна.

Профессор Х.Курибаяшийн энэхүү бүтээл орчин үеийн монгол судлалын хөгжлийн өндөр түвшинг илтгэн харуулсан тун чамбай ажил болсныг онцлон тэмдэглэмээр байна. Ялангуяа нэг хуудсанд латин галиг, нөгөө хуудсанд эхийг нь зэрэгцүүлэн хэвлэсэн нь харьцуулж үзэхэд хялбар дөхөм болжээ.

1918 оны эх дээр үсэг тэмдэг орхисон зэрэг алдаатай зүйлийг нэг бүрчлэн жагсаан, дор дор нь засаж залруулсан нь нэн сайшаалтай. Жишээ нь; mede'et (мэдээд) хэмээх үгийн дэвсгэр –t гийгүүлэгчийг эх зохиолд орхиж тэмдэглэснийг mede=e[t] гэж галиглаад доор нь <<2:25a3 箋迭額 (箋迭額楊)>>(29:88) гэж хаалтан дотор засаж бичсэн байна.

Толь бичгийг 4-5 баганаар байрлуулав. Тодруулвал; Эхний бага нанд эх зохиолын хуудасны дугаар, II багана 844 үгийн чухам

хэддүгээр үг болохыг заасан дугаар, III багана нангиад үг, IV б монгол эхийн латин галиг, V багана хэрэв монгол үгийг галиг алдсан бол залруулсан тэмдэглэгээ зэрэг болно. Тухай <<1:10a6 281 箸 yatuqan 牙土罕 (牙土[中]罕)>> (29:26) гэх мэт

Эцэст нь тэмдэглэхэд , уул номд оруулсан эх өмнө хүм хэвлүүлснээс илүү тод сайхан болсон байна.

Япон, Хятад эрдэмтэд ч "Хуа-и И-юй" толийг судалсан бүтээл гаргасан сураг чимээ байх боловч бид олж үзээгүй тул зүйл огт алга. Түүнчлэн "Хуа-и И-юй" толийг судалсан олон өгүүлэл Өвөр монгол болон бусад оронд гарсан бөгөөд тэр бс талаар өгүүлэх боломж үгүй учир тухайн судлаачдаас хүлчил е

Бид эдүгээ "Хуа-и И-юй" толийг бүрэн эхээр нь хэвлүүлж Урьд өмнө нь энэ толийг манай улсад нийтэлж байгаагү мэргэжлийн ангийн оюутнууд нэрийг нь сонссоноос цаашгүй ө өргөн олон түмэн бараг мэдэхгүй буй за.

Гэтэл уг толь "И-юй" маягийн толиуд дотроос хэмжээгээ агуулга ач холбогдлоороо ч хамгийн чухал, монгол үгийг галиг систем нь тун нарийн юм. Бусад толиуд нь ерийн үгсийн цуг шинжтэй бол "Хуа-и И-юй" толийн дэд дэвтэрт унших хэрэглэ болгон 12 эх бичгийг хавсаргасан байх тул "Монголын Товчоон"-ы дараа орохуйц үнэ цэнтэй хэрэглэгдхүүн болдог би

Нөгөөтэйгүүр , энэхүү 12 бичвэр Юань гүрэн мөхсөний д хэдэн жил буюу 1368-1388 оны үеийн Монгол, Мингийн улс т харилцааны түүхийг тодруулан судлахад ховор хэрэглэгдэхүүн болох тул их дээд сургуулийн монгол, хятад х бичиг судлал, сурвалж судлал, түүх зэрэг ангийн оюутнуудад гарын авлага болно.

Ер нь монголын соёлыг сонирхдог хэн боловч энэ бари олон зүйл олох нь дамжиггүй.

Нарийн мэргэжлийн судлаачдад бус оюутан залуус, сон олон түмэнд зориулж байгаа тул нэлээд нуршуу "Уди бичсэнийг маань болгооно уу.

Уул товхимол нь;

1. Удиртгал
2. "Хуа-и И-юй" толийн дээд дэвтрийн латин галиг, шинэ хөрвүүлэг.
3. Доод дэвтрийн латин галиг.
4. Шинэ үсгийн хөрвүүлэг.
5. Зарим үг хэллэгийн товч тайлбар.
6. Ном зүй .
7. Эхийн гэрэл зураг гэсэн бүтэцтэй юм.

Бид уг номын тэргүүн дэвтрийн галиг хөрвүүлгийг дараах байдлаар хэвлэв. Үүнд, эхний эгнээнд уг эх зохиолын хуудас ба мөрийн дугаар, удаах нь тухайн үгийн тольд байрлах дэс дугаар, ~~үгийн латин галиг, тольд байрлах дэс дугаарын хамт~~, гуравдугаар эгнээнд латин галиг, дөрөвдүгээр эгнээнд шинэ үсгийн хөрвүүлэг, сүүлийн эгнээнд эх зохиолд алдаатай бичигдсэн үгсийг байгаагаар нь галиглан орууллаа. Жишээлбэл,

<< I:16r1 453. burqan бурхан burhan >>

гэхэд, дээд дэвтрийн 16-р хуудасны өвөр талын 1-р мөрд байх 453-р үг болно. 不児中罕(burqan) хэмээн бичих ёстой атал монгол хэлний, үгийн гүн угийн хамжин тэсрэх q авиаг нангиад галигт тэмдэглэдэг 中 үсгийг 1918 онд хэвлэгдсэн "Хуа-и И-юй" тольд орхин 不児罕(burhan) гэж бичжээ хэмээн ойлговол зохино. Түүнчлэн ташаа бичлэгтэй үгийн ард дугуй хаалтан дотор "<" тэмдэг тавиад зөв болов уу гэсэн хэлбэрийг тавьсныг анхаарна уу. Жишээ нь : talibi -(< talbi-) гэх мэт.

Дэд дэвтэр буюу 12 бичгийг галигласан хүмүүсийн дотроос профессор А. Мостэртийн галиг(23) хамгийн нягт сайн болсон тул түүнийг бид энэхүү ажилдаа шууд оруулсан бөгөөд өргөн олон түмэнд тус дэм болох үүднээс бичвэрүүдийг шинэ үсэгт буулгаж зарим үг хэллэгт товч тайлбар хийв.

Аливаа эх бичгийн судалгаа хийхэд эх зохиолыг эс хэвлүүлвээс учир дутагдалтай, итгэл үнэмшил муутай болдог тул эхийн хуулбарыг Х. Курибаяшийн номоос(29) авч хавсаргасны зэрэгцээ цаашид лавшруулан судлах хүмүүст зориулж холбогдох ном зүйг эцэст нь орууллаа.

Бидний ажлыг ариутган шүүсэн хэлшинжлэлийн ухааны доктор, профессор Л. Болд, цахим бичвэрт шивэх, эхийн гэрэл зургийг татаж оруулах зэрэг бүхий л техник ажлыг сэтгэл харамгүй, нягт нямбай гүйцэтгэж тусалсан Г. Мөнхбаяр нартаа чин зүрхний талархал дэвшүүлье.

Энэ ажил маань анхны оролдлого бөгөөд бидний мэдлэг оюун мөхөсийн харгайгаар алдаа эндэгдэл байх нь лавтай тул мэргэн оюунт уншигч та бүхэн осол цалгайг ариутган соёрхох аваас гүнээ талархах болно.

XVII жарны "Наран" хэмээх усан
хонин жилийн хаврын адаг улаан
луу сарын өлзийт сайн өдөр
Зохиогчид

"ХУА-И И-ЮЙ" толийн дээд дэвтрийн латин галиг, шинэ үсгийн ХӨРВҮҮЛЭГ

“ХУА-И И-ЮЙ” толийн дээд дэвтрийн латин галиг, шинэ үсгийн хөрвүүлэг

I:01r1				
I:01r2		Тэнгэрийн утгын зүйл		
I:01r3	1.	tenggiri	тэнгэр	
	2.	naran	нар	
I:01r4	3.	sara	сар	
	4.	hodun	од	
I:01r5	5.	kei	салхи	
	6.	e'ülen	үүл	
I:01r6	7.	hunin	утаа, униар	
	8.	kira'u	хяруу	
I:01r7	9.	mölsün	мөс	
	10.	časun	цас	
I:01r8	11.	tenggiri dongqodum	тэнгэрийн дуу, аянга	
	12.	jüse	зүс бороо, зүсэр бороо	
I:01v1	13.	qura	хур бороо	
	14.	ši'üderin	шүүдэр	
I:01v2	15.	solangqa	солонго	solangha
	16.	moniyar	униар манан	
I:01v3	17.	gilibeligen (< gilbelgen)	цахилгаан	
	18.	mündür	мөндөр	
I:01v4	19.	tenggri-yin oyalar	тэнгэрийн оёдол	
I:01v5		Газарзүйн зүйл		
I:01v6	20.	qajar	газар	
	21.	šira'u	шороо	

I:01v7	22.	a'ula	уул	
	23.	hoi	ой	
I:01v8	24.	müren	мөрөн	
	25.	na'ur	нуур	
I:02r1	26.	qoroqan	горхи	qorohan
	27.	če'el	цээл	
I:02r2	28.	qumaki	хумхи	
	29.	bulaq	булаг	
I:02r3	30.	subaq	суваг	
	31.	tariyan	тариа	
I:02r4	32.	baq	хашаа, цэцэрлэг	
	33.	šibe'e	шивээ	
I:02r5	34.	yoqurqa	хана, хэрэм	
	35.	to'osun	тоос	
I:02r6	36.	šibar	шавар	
	37.	šilde'en	тосгон, гацаа	
I:02r7	38.	usun	ус	
	39.	dalai	далай	
I:02r8	40.	doligiyan(< dolgiyan)	долгион	
	41.	elesün	элс	
I:02v1	42.	ergi	эрэг	
	43.	üyer	үер	
I:02v2	44.	čila'un	чулуу	
	45.	ke'er	хээр	
I:02v3	46.	mör	зам, зам мөр	
	47.	daba'an	даваа	
I:02v4	48.	ködö'e	хөдөө	
	49.	bo'om	боомт	
I:02v5	50.	amasar	амсар	
	51.	balaqasun	балгас	balahasun
I:02v6	52.	ulus	улс	
	53.	badzar	зах, зээл	
I:02v7	54.	guduq(< quduq)	худаг	
	55.	güriyen	хүрээ	
I:02v8	56.	terge'ür	дардан зам	
	57.	obo'o	овоо	
I:03r1		Цаг улирлын зүйл		
I:03r2	58.	qabur	хавар	
	59.	jun	зун	

I:03r3	60.	namur	намар	
	61.	übül	өвөл	
I:03r4	62.	čaq	цаг	
	63.	hon	он	
I:03r5	64.	üdür	өдөр	
	65.	söni	шөнө	
I:03r6	66.	üdür düli	өдөр дунд, үд	
	67.	üdeši	үдэш	
I:03r7	68.	čiliger(< čilger)	аагим халуун	
	69.	köyiten	хүйтэн	
I:03r8	70.	büliyen	бүлээн	
	71.	seri'ün	сэрүүн	
I:03v1	72.	qala'un	халуун	
	73.	dula'an	дулаан	
I:03v2	74.	körbei	хөлдөв, хөлдөх	
	75.	jö'en	хүйтэн, жихүүн	
I:03v3	76.	qata'ar	хатах, ган, гандуу	
	77.	manaqar erte	өглөө эрт	manahar erte
I:03v4	78.	üdür šini	шинийн нэгэн	
	79.	jabusar söni(< jabsar söni)	бүтүүн	
I:03v5	80.	beler erde	балар эрт	
	81.	edö'e	одоо, эдүгээ	
I:03v6		Цэцэг модны зүйл		
I:03v7	82.	narasun	нарс	
	83.	arča	арц	
I:03v8	84.	gulusun(< qulusun)	хулс	
	85.	čigörsün	цөөрс	
I:04r1	86.	qailasun	хайлаас	
	87.	hičesün	уд	
I:04r2	88.	boro kečeü	чавчирга	
	89.	čibuqan	чавга	
I:04r3	90.	alima	алим	
	91.	jemiši(< jemiš)	жимс	
I:04r4	92.	güilesün	гүйлс	
	93.	üdzüm	үзэм	
I:04r5	94.	ji'aq	самар, хушга	
	95.	čeček	цэцэг	
I:04r6	96.	geši'ün	гишүү, мөчир	

	97.	nabučin(< nabčin)	навч	
I:04r7	98.	huja'ur	ёзоор, үндэс	
	99.	qamqa'ul	хамхуул	hamqa'ul
I:04r8	100.	širalijin(< širaljin)	шарилж	
	101.	hüre	үр	
I:04v1	102.	qonoq	хоног будаа	
	103.	arpai	арвай	
I:04v2	104.	bu 'udai	буудай	
	105.	tuturqan	тутарга, цагаан будаа	
I:04v3	106.	amun	амуу	
	107.	burčaq	буурцаг	
I:04v4	108.	qoqosun	гогод	
	109.	so'onggina(<songgina)	сонгино	
I:04v5	110.	sarimsaq	саримс	
	111.	manggir	мангир	
I:04v6	112.	qa'un	амтат гуа	
	113.	arbus	шийгуа	
I:04v7	114.	qabaq	хулуу	
	115.	badingqa	цэс, хаш	
I:04v8	116.	kiči	гич	
	117.	turma	улаан лууван	
I:05r1	118.	ebesün	өвс	
	119.	modun	мод	
I:05r2		Жигүүртэн араатны зүйл		
I:05r3	120.	lu	луу	
	121.	bars	барс	
I:05r4	122.	kers	хирс	
	123.	arslan	арслан	
I:05r5	124.	ötögö	баавгай	
	125.	morin	морь	
I:05r6	126.	aqta	аГт	
	127.	ajirqa	азрага	ajirha
I:05r7	128.	ge'ün	гүү	
	129.	lausa	луус	
I:05r8	130.	elijigen(< eljigen)	илжиг	
	131.	unuqan	унага	unuhan

I:05v1	132.	hüger	үхэр	
	133.	qonin	хонь	
I:05v2	134.	jēren	зээр	
	135.	qaqai	гахай	
I:05v3	136.	qaban	зэрлэг гахай	
	137.	tuqul	тугал	
I:05v4	138.	čü'eberi	цөөвөр чоно	
	139.	čino	чоно	
I:05v5	140.	bečin	бич	
	141.	hünegen	үнэг	
I:05v6	142.	kirsa	хярс	
	143.	ara[q]tai	марал	aratai
I:05v7	144.	buqu	буга	
	145.	buluqan	булга	buluhan
I:05v8	146.	qarqulaq	бамбар	qarhulaq
	147.	miši(< miš)	муур	
I:06r1	148.	teme'en	тэмээ	
	149.	ja'an	заан	
I:06r2	150.	taulai	туулай	
	151.	jiqar	хүдэр	jihar
I:06r3	152.	qali'un	халиу	
	153.	noqai	нохой	nohai
I:06r4	154.	güčük	гөлөг	
	155.	otas	сарлаг	
I:06r5	156.	jariya	зараа	
	157.	mekeiji(< mekeji)	мэгж	
I:06r6	158.	üne'en	үнээ	
	159.	buqa	бух	
I:06r7	160.	ima'an	ямаа	
	161.	quluqana	хулгана	huluqana
I:06r8	162.	noman	сохор номин	
	163.	quriqan	хурга	qurihan
I:06v1	164.	quča	хуц	huča
	165.	uquna	ухна	
I:06v2	166.	jiqasun	загас	
	167.	naq menegei	лаг мэлхий	
I:06v3	168.	menegei	мэлхий	
	169.	ha'alijin(< ha'aljin)	аалз	
I:06v4	170.	herbegei	эрвээхэй	
	171.	moqai	могой	mohai
I:06v5	172.	bökö'üne	батгана	

	173.	šimu'ul	шумуул	
I:06v6	174.	čeürge	нүгэлт царцаа	
	175.	qalitu qoroqai(< qaltu qoroqai)	галт хорхой	qalitu qorohai
I:06v7	176.	qoroqai	хорхой	qolohai
	177.	široqaljin	шоргоолж	širohaljin
I:06v8	178.	bö'esün	бөөс	
	179.	bürge	бүүрэг	
I:07r1	180.	kökö teri'ün	хөх түрүү	
	181.	jumuran	зурам	
I:07r2	182.	yasutu menegei	яст мэлхий	
	183.	šibawun	шувуу	
I:07r3	184.	qarudi	гарди	qaludi
	185.	bürügüt	бүргэд	bülügüt
I:07r4	186.	alaq ta'un	алагтуу	
	187.	tura'un	хэрээ	tula'un
I:07r5	188.	küčeye	ойн тагтаа	
	189.	üli	ууль	
I:07r6	190.	qarčiqai	харцага	harčihai
	191.	kirgui	хяргуй	
I:07r7	192.	hele'e	элээ	
	193.	takiya	тахиа	
I:07r8	194.	qalawun	галуу	
	195.	anggir	ангир	
I:07v1	196.	toti	тоть	
	197.	qariyača	хараацай	haliyača
I:07v2	198.	sājiqai	шаазгай	sājihai
	199.	qurqa'ul	гургуул	hurqa'ul
I:07v3	200.	kökörčigen	хүүрэгэнэ, тагтаа	
	201.	noqosun	нугас	
I:07v4	202.	šira šibawun	шар шувуу	
	203.	kidarčiqan	хятруун бялзуухай	kidarčihan
I:07v5	204.	tawus	тогос	
	205.	šingqor	шонхор	šinghor
I:07v6	206.	qun	хун	
	207.	lačin	начин шонхор	
I:07v7	208.	itelögü(< itelgü)	идлэг шонхор	
	209.	turimtai	туримтай шонхор	
I:07v8	210.	bödene	бөднө	

	211.	sar	сар	
I:08r1	212.	čuqur	өвөгт хэрэмч	čuqur
	213.	laq	хар бүргэд	
I:08r2	214.	jaqalimai	загалмай шонхор	jahalimai
	215.	qara'una	харууна, усан хэрлэг	
I:08r3	216.	ödün	өд	
	217.	jiwür	жигүүр	
I:08r4	218.	ba'ul	сарвуу	
	219.	turu'un	туруу, туурай	tulu'un
I:08r5	220.	eber	эвэр	
	221.	arasun	арьс	
I:08r6	222.	qoši'un	хошуу	hoši'un
	223.	del	дэл	
I:08r7	224.	se'ül	сүүл	
	225.	qairsun	хайрс	
I:08r8	226.	köyisün	хүйс	
	227.	yasun	яс	
I:08v1	228.	ömdegen	өндөг	
	229.	nisqu	нисэх	
I:08v2	230.	güikü	гүйх	
	231.	ing[g]uličaqam(< ingqulčaqam)	янцгаах, унгалдах	inguličah
I:08v3	232.	qučam	хуцна	hučam
	233.	mö'erem	мөөрнө	
I:08v4	234.	mailam	майлна	
	235.	mürgüčelidüm (< mürgüčeldüm)	мөргөцөлдөнө, мөргөлдөнө	
I:08v5		Орд гэрийн зүйл		
I:08v6	236.	ordo ger	орд гэр	
	237.	e'üden	үүд	
I:08v7	238.	qa'alqa	хаалга	ha'alqa
	239.	bosoqa	босго	bosoha
I:08v8	240.	ger-ün niri'un	гэрийн нуруу	
	241.	ger-ün qabusun	гэрийн унь	ger-ün habusun
I:09r1	242.	tulqa	тулга	tulha
	243.	ger	гэр	

I:09r2	244.	ke'ürge	гүүр	
	245.	kerbiši	тоосго	
I:09r3	246.	kebit	мухлаг	
	247.	süme ger	сүм гэр	
I:09r4	248.	qoriyan	хороо	qoliyan
	249.	suburqan	суврага	
I:09r5	250.	čaqurasun	ваар	čahurasun
	251.	ni'e-	нээ-	
I:09r6	252.	qa'a-	хаа-	
I:09r7		Сав хэрэглэлийн зүйл		
I:09r8	253.	tergen	тэрэг	
	254.	gürdün	хүрд	
I:09v1	255.	aral	арал	
	256.	kekesün	хигээс	
I:09v2	257.	mö'er	мөөр	
	258.	bulu	бул	
I:09v3	259.	ing[g]ulaq	чингэлэг	
	260.	čilbur	цулбуур	
I:09v4	261.	mina'a	ташуур	
	262.	qalqa	бамбай	
I:09v5	263.	jida	жад	
	264.	üldü	илд	
I:09v6	265.	süke	сүх	
	266.	numun	нум	
I:09v7	267.	kö[b]či	хөвч	köči
	268.	orangqa	туг, дарцаг	
I:09v8	269.	qada'ar	хазаар	
	270.	dörö'e	дөрөө	
I:10r1	271.	quyaq	хуяг	
	272.	du'uluqa	дуулга	
I:10r2	273.	sumun	сум	
	274.	orbu'ur	буу	
I:10r3	275.	körge	их хэнгэрэг	
	276.	kenggerge	бага хэнгэрэг	
I:10r4	277.	anjasun	анжис	
	278.	qadu'ur	хадуур	
I:10r5	279.	ongqača	онгоц	
	280.	de'esün	дээс	
I:10r6	281.	yatuqan	ятга	yatuhan

	282.	lungqa(< longqa)	лонх	
I:10r7	283.	čaqun ayaqa	цайны аяга	čahun aya
	284.	talabar	таваг	
I:10r8	285.	iraqa	буцалгуур	
	286.	qalbuqa	халбага	halbuqa
I:10v1	287.	čara	цар	
	288.	jebüke(< jebke)	дэвүүр, сэвүүр	
I:10v2	289.	čiq	орхиул, хөшиг	
	290.	gümerge	хөмрөг, хорго	
I:10v3	291.	huquta	уут	huhuta
	292.	sam	сам	
I:10v4	293.	jö'ün	зүү	
	294.	jula	зул	
I:10v5	295.	julabči	зулын цөгц	
	296.	gečigi'ür	гишгүүр	
I:10v6	297.	sorbi	таяг	
	298.	ši'ürge	шүүр	
I:10v7	299.	tamqa	тамга	
	300.	saba	сав	
I:10v8	301.	üdzük	үзэг	
	302.	ča'alsun	цаас	
I:11r1	303.	beke	бэх	
	304.	gölimi(< gölmi)	загасны тор	
I:11r2	305.	qubuči'ur(< qubči'ur)	загасны гувчуур	hubuči'ur
	306.	toqo'an	тогоо	toho'an
I:11r3	307.	qongqo	нүдүүр	hongho
	308.	a'ur	уур	
I:11r4	309.	ayaqa	аяга	
	310.	širi'e	ширээ	
I:11r5	311.	toli	толь	
	312.	či'i'ülsün	чийрс	
I:11r6	313.	iseri	исэр, ор	
	314.	dere	дэр	
I:11r7	315.	batman	жинлүүр	
	316.	qayiči	хайч	hayiči
I:11r8	317.	čo'orqa	цуурга, оньс	
	318.	türi'ür	түлхүүр	
I:11v1	319.	sanjali	сандал	
	320.	čargi	царгил хөгжим	
I:11v2	321.	čang	цан	

	322.	qal	гал	
I:11v3	323.	ne'üresün	нүүрс	
I:11v4		Хувцас хунарын зүйл		
I:11v5	324.	de'el	дээл	
	325.	qormai	хормой	
I:11v6	326.	nekei de'el	нэхий дээл	
	327.	čaruq	чархи гутал, шаахай	čaluq
I:11v7	328.	qudusun	гутал	
	329.	sisgei	эсгий	
I:11v8	330.	olosun	олс	
	331.	juja'an de'el	зузаан дээл	
I:12r1	332.	de'el-ün jaqa	дээлийн зах	de'el-ün jaha
	333.	qančun	ханцуй	hančun
I:12r2	334.	büči	бүч	
	335.	büči	бүч	
I:12r3	336.	büse	бүс	
	337.	emüdür	өмд	
I:12r4	338.	debüsger	дэвсгэр	
	339.	könjile	хөнжил	
I:12r5	340.	kösige	хөшиг	
	341.	hoyimosun	оймс	
I:12r6	342.	čama	цэмбэ	
	343.	qarqumi	хатгамал	harhumi
